



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/459

Мөрөн сум

Улсын салбарын дотоод аудитыг
Хөвсгөл аймагт хөгжүүлэх дунд хугацааны
стратеги төлөвлөгөө батлах, түүнийг
хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Дотоод аудитын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Улсын салбарын дотоод аудитыг Хөвсгөл аймагт хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-г 1 дүгээр, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөтөлбөрт арга хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стратеги төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын зээл, тусламж, төсөлд хамруулах замаар санхүүжүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлж, тайланг жил бүр Дотоод аудитын хорооны хуралд танилцуулж байхыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Г.Мөнхтулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

УЛСЫН САЛБАРЫН ДОТООД АУДИТЫГ ХӨВСГӨЛ АЙМАГТ ХӨГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төсвийн тухай хууль, Дотоод аудитын дүрэмд зааснаар Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дотоод аудитын үйл ажиллагааг стандарт, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах үүрэг хүлээсэн бөгөөд Улсын салбарын дотоод аудитыг төв орон нутагт чанарын нэгдсэн түвшинд хүргэх, Дотоод аудитын чадавхийг бэхжүүлэх, бие даасан хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг эрсдэлээс сэргийлэх, засаглалыг бэхжүүлэх зорилго нь "Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийг боловсруулах үндэслэл болно" гэж тодорхойлсон байна.


Хоёр. Стратегийн үндсэн зорилго, зорилт

2.1 Стратегийн зорилго

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3-Эдийн засгийн бодлого, Зөв төлөвлөлт-Өгөөжтэй эдийн засаг, 3.1.Аймгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд оновчтой бодлогыг тодорхойлж, нийгмийн хөгжлийн зорилт хэрэгжихүйц, иргэдийн оролцоотой, ил тод, хариуцлагатай төсвийн орчинг бүрдүүлнэ, 3.1.14.Төрийн байгууллагуудын дотоод хяналтаар санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх чадавхийг бий болгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шат ахисан сургалт явуулах, эрсдэлийг анхан шатанд удирдан, зөрчлийн хувь хэмжээг бууруулна, 3.1.15.Улсын салбарын дотоод аудитын стандартыг аймаг орон нутагт нэвтрүүлэх 2021-2024 оны дунд хугацааны стратеги төлөвлгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

2.2. "Улсын салбарын дотоод аудитыг Хөвсгөл аймагт хөгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийн зорилго нь дотоод аудит, дотоод хяналтын тогтолцоог орон нутгийн түвшинд боловсронгуй болгох, дотоод аудиторын практик ур чадварыг дээшлүүлэх, дотоод аудитыг мэргэжлийн өндөр түвшинд чанар, стандарт шалгуурт нийцүүлэн хэрэгжүүлэхэд оршино.

2.2. Зорилгыг дараах зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлнэ.



Гурав. Стратегийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

3.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь “Улсын салбарын дотоод аудитыг Хөвсгөл аймагт хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-нд туссан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор орон нутгийн төрийн байгууллагуудыг стандарт, удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.

3.2 Стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө буюу хөтөлбөрт тусган улс, орон нутгийн төсөв болон гадаадын буцалтгүй тусламж, төслийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

3.3 Хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болон бүх шатны төрийн байгууллагын удирдлага, дотоод аудитор, дотоод хяналтын нэгжүүд хүлээнэ.

3.4 Стратегийн агуулга, чиглэлд өөрчлөлт оруулах бол холбогдох байгууллагуудын саналыг тусган хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

3.5 Стратеги төлөвлөгөө нь зөвхөн төрийн байгууллагын хүрээнд хэрэгжих бөгөөд хэрэгжилтэнд Засаг дарга ба түүний дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хяналт тавьж ажиллана.

Дөрөв. Стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1.1. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний **3-Эдийн засгийн бодлого, Зөв төлөвлөлт – Өгөөжтэй эдийн засаг 3.1.** Аймгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд оновчтой бодлогыг тодорхойлж, нийгмийн хөгжлийн зорилт хэрэгжихүйц, иргэдийн оролцоотой, ил тод, хариуцлагатай төсвийн орчинг бүрдүүлнэ, **3.1.14.Төрийн байгууллагуудын дотоод хяналтаар** санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх чадавхийг бий болгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шат ахисан сургалт явуулах, эрсдэлийг анхан шатанд удирдан, зөрчлийн хувь хэмжээг бууруулна, **3.1.15.**Улсын салбарын дотоод аудитын стандартыг аймаг орон нутагт нэвтрүүлэн ажиллана.

4.1.2 Улсын салбарын дотоод аудитыг Хөвсгөл аймагт хөгжүүлэх /2023-2025 он/ дунд хугацааны стратегийг үндэслэн түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хөтөлбөр хэлбэрээр гаргаж, Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж, батлуулах.

4.1.3 Дотоод аудит ба дотоод хяналтын талаарх мэдлэгийг түгээх, сурталчлах.

4.1.4 Байгууллагуудын дотоод хяналтаар санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх чадавхийг бий болгож, эрсдэлийг анхан шатанд удирдан, зөрчлийн хувь хэмжээг бууруулах.

4.1.5 Дотоод хяналтын нэгжид нэгдсэн мэдлэг олгох сургалт зохион байгуулах.

4.1.6. Дотоод хяналтын үнэлгээний журам боловсруулж, нэвтрүүлэх.

4.1.7. Дотоод хяналтын үнэлгээний үр дүнг хүний нөөцийн болон байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх үнэлгээтэй уялдуулж байх

4.1.8. Төрийн байгууллагуудын дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, засаглал сэдвээр төсвийн шууд захирагч болон эрсдэл хариуцсан албан хаагчдад сургалт мэдээллийг хүргэх. Энэ чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.

4.1.9. Төсвийн болон орон нутгийн өмчит ААНБ-ын дотоод хяналт, дотоод аудит хариуцсан ажилтнуудад практик дадал олгох, сургалтыг шат дараалан хэрэгжүүлэх.

4.2. Дотоод аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэх:

4.2.1. Дотоод аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн системийг Дотоод аудитын нэгжид нэвтрүүлэх;

4.2.2. Дотоод аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн системд улсын салбарын дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдын хүний нөөц, сургалт, мэдлэг, ур чадвар, боловсрол, туршлагын талаарх мэдээллийг оруулах;

4.2.3. Мэдээллийн системд аудит, хяналт шалгалтын бүх үе шат буюу Дотоод аудитын олон улсын стандарт, холбогдох дүрэм, журам, гарын авлага, аргачлалд нийцүүлэн ажлын маягт загварыг оруулах, системээс мэдээлэл авах, систем ашиглаж аудит, хяналтын ажлыг гүйцэтгэж хэвших;

4.2.4. Дотоод аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн систем ашиглаж эрсдэлийн үнэлгээ, бүртгэхийг хийж хэвших.

4.2.5. Дотоод аудитын бүтэц, дотоод аудитын хорооны оновчтой зохион байгуулалтыг бий болгох, дотоод аудитуудыг зэрэг дэв олгох, мэргэшүүлэх сургалтанд хамруулж, чадавхийг бэхжүүлэх, хараат бус бие даасан байдлыг хангах

4.2.6. Аймгийн ТЕЗ-ын дэргэдэх дотоод аудитын байгууллагын үндсэн бүтцийг холбогдох хуульд нийцүүлэн, зохион байгуулж, ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэн, дотоод аудитын хорооны оновчтой зохион байгуулалтыг бий болгох

4.2.7. Дотоод аудитуудыг зэрэг дэв олгох, мэргэшүүлэх сургалтанд хамруулж, чадавхийг бэхжүүлэх

4.2.8. Дотоод аудитуудын бие даасан, хараат бус байдлыг хангах

4.2.9. Сургалт болон дотоод аудит хийхэд шаардлагатай арга зүйн баримт бичиг, гарын авлага, олон улсын мэргэжлийн практик хүрээ (IPPF)-ний шинэчлэлтийг тусган шинэчилсэн баримт бичгийг ашиглах.

4.2.10. Сангийн яамнаас баталсан дотоод аудитын чанарын баталгаажуулалтын үнэлгээний журамд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж хэвших.

4.3. Эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх:

4.3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын Дотоод аудитын нэгжүүд эрсдэлийн үнэлгээг өөрсдөө хийж хэвших;

4.3.2. Эрсдэлийн удирдлагын сургалт зохион байгуулах;

4.3.3. Төсвийн шууд захирагч нар өөрийн хариуцсан нэгжийн эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн удирдлагаар хангах.

Тав. Хэрэгжүүлэх үе шат, санхүүжилт

5.1 “Улсын салбарын дотоод аудитыг Хөвсгөл аймагт хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г 2023-2025 онуудад хэрэгжүүлнэ.

5.2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаад зээл, буцалтгүй тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Зургаа. Хүрэх үр дүн

6.1. Дотоод аудитын нэгж, хорооны үйл ажиллагаа шинэ шатанд гарсан байна.

6.2. Дотоод аудитын нэгдсэн мэдээлэлийн системд холбогдсон байна.

6.3. Дотоод аудит болон дотоод хяналтын холбогдох гарын авлагууд болон стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн байна.

6.4. Төсвийн болон орон нутгийн өмчит ААНБ-д дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажилласан байна.

6.5. Дотоод аудитын чанарын баталгаажуулалтын хөтөлбөр, үйл ажиллагаа жигдэрнэ.

6.6. Улсын салбарын мэргэшсэн дотоод аудиторын зэрэг олгох сургалтанд бүх ажилтнууд хамрагдаж, зэрэг дэв авч эхэлнэ.

6.7. Эрсдэлийн удирдлагын арга аргачлал, баримт бичгүүдийг байнга ашиглаж, эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.

6.8. Эрсдэлийн хяналт, бүртгэлийн системд холбогдсон байна.

6.9. Дотоод аудит, дотоод хяналтын үйл ажиллагааны талаар аймгийн хэмжээнд сурталчилан таниулах арга хэмжээг тогтмол зохион байгуулсанаар иргэд, олон нийтийн дотоод аудитын мэдлэг, хандлага өөрчлөгдсөн байна.

Долоо. Бусад

7.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын нэгж нь стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах үүрэгтэй бөгөөд хэрэгжилтийн явц, үр дүнг Дотоод аудитын хороонд жил бүр тайлагнаж ажиллана.

7.2. Стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтэнд Сангийн яам болон бусад холбогдох байгууллагаар хяналт, шинжилгээ үнэлгээ хийлгэж, Дотоод аудитын хороонд тайлагнана.


7.3. Энэхүү 3 жилийн хугацаатай хэрэгжих стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тайлант он тус бүрд нарийвчлан гаргаж, Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилт хангаж ажиллана.

7.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Дотоод аудитын нэгжийг стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахад бодлого арга зүйгээр Төсвийн ерөнхийлөн захирагч болон, дотоод аудитын хороо дэмжиж ажиллана.

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР  А.ДОГСМОО

ХЯНАСАН:

АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Г.МӨНХТУЛГА.

Аймгийн Засаг даргын 2023 оны
09 сарын 09 ны өдрийн АТГ-г
захирамжийн хоёрдугаар хавсралт

УЛСЫН САЛБАРЫН ДОТООД АУДИТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХӨВСГӨЛ АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (2023-2025 ОН)

Зорилт	Төлөвлөгөө	Хэрэгжүүлэх ажил	Хүрэх үр дүн	Хариуцах	Хугацаа
Зорилт 1. Дотоод аудит, дотоод хяналтын эрх зүйн орчныг сайжруулах.	1.1. Улсын салбарын дотоод аудитын тухай хуулийн төсөлд санал хүргүүлэх.	1.1.1. Хуулийн төслийг өргөн мэдүүлэх ажлын хэсэгт санал хүргүүлэх	Улсын салбарын Дотоод аудитын тухай хуулийн төсөлд санал хүргүүлсэн байх	СХДАА	2023-2025
	1.2. Улсын салбарын дотоод аудитын тухай хуультай нийцүүлэн Дотоод аудитын нэгжид мөрдөгдөх шаардлагатай эрх зүйн баримт бичгийг боловсруулах.	1.2.1. Дотоод аудиторын ёс зүйн дүрэм боловсруулах. 1.2.2. Дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой бусад дүрэм, журмыг боловсруулах, шинэчлэх. 1.2.3. Дотоод аудитын байгууллагын үндсэн бүтцийг холбогдох хуульд нийцүүлэн, зохион байгуулж, ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэн, дотоод аудитын хорооны оновчтой зохион байгуулалтыг бий болгох	Олон Улсын жишигт нийцсэн дүрэм, журам боловсруулсан байх.	СХДАА	2023-2025
	1.3. Дотоод аудитын нэгжийн хараат бус бүтэц, зохион байгуулалттай байх.	1.3.1. Дотоод аудитын бүтэц хараат бус байдлаар хангагдсан байх. 1.3.2. Дотоод аудитор авлига, зөрчилд өртөхөөс сэргийлсэн цалин урамшууллын зохистой тогтолцоог бүрдүүлэх. 1.3.3. Дотоод аудитын тогтолцоо, дотоод хяналтын үйл ажиллагааг эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хэмжээнд таниулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж төрийн албан хаагчид иргэд, олон нийтийн дотоод аудит, дотоод хяналтын талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлнэ.	-Дотоод аудитын хараат бус бүтэц, зохион байгуулалт хийгдсэн байх. -Дотоод аудитын талаарх иргэд, олон нийтийн мэдлэг дээшилсэн байх. -Цалин урамшууллын оновчтой тогтолцоо бүрдсэн байх	СХДАА	2023-2025

		1.3.4.Дотоод аудитын байгууллагын үндсэн бүтцийг холбогдох хуульд нийцүүлэн, зохион байгуулж, ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэн, дотоод аудитын хорооны оновчтой зохион байгуулалтыг бий болгох			
	1.4. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3-Эдийн засгийн бодлого, Зөв төлөвлөлт “Өгөөжтэй эдийн засаг” аймгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд оновчтой бодлогыг тодорхойлж хэрэгжүүлсэн байх.	1.4.1.Төрийн байгууллагуудын дотоод хяналтаар санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх чадавхийг бий болгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шат ахисан сургалтын явуулсан байх. 1.4.2.Төрийн байгууллагуудын дотоод хяналт, засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлнэ.	СХДАА		
Зорилт 2. Дотоод аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэх	2.1.Дотоод аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэх.	2.1.1.Дотоод аудит, хяналт шалгалтын мэдээллийн системд дотоод аудитын нэгжид нэвтэрсэн байна.	-Систем бэлэн болсон байх. -Холбогдох мэдээллийг бүрэн тусгах. -Системийн сургалтад хамрагдсан байх.	СХДАА Т	2023-2025
	2.2.Дотоод аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн системд улсын салбарын дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдын мэдээллийг тусгах.	2.2.1.Дотоод аудит-хяналт шалгалтын мэдээллийн системд хүний нөөц, сургалт, аудиторуудын мэдлэг, ур чадвар, боловсрол, туршлагын мэдээллийг тусгах.	-Хүний нөөц, сургалт, аудиторуудын мэдлэг, ур чадвар, боловсрол, туршлагын мэдээлэл системд орсон байх. -Сургалтын хөтөлбөр, мэдээлэл цахим системд шилжсэн байх.	Сангийн яам ТЕЗ-ийн ДАН	2023-2025
	2.3.Дотоод гүйцэтгэхэд шаардлагатай	2.3.1.Мэдээллийн системд аудит, хяналт шалгалтын бүх үе шатыг ДАОУС, холбогдох	Дотоод аудит гүйцэтгэх үйл явц хялбаршиж,	СХДАА	2023-2025

	мэдээллийн системд ДАОУС, холбогдох дүрэм, журам, гарын авлагын загварыг оруулах, ашиглаж хэвших.	дүрэм, журам, гарын авлага, аргачлалд нийцүүлэн ажлын маягт загварыг оруулах. 2.3.2.Дотоод аудит гүйцэтгэхэд шаардлагатай программ хангамжийг нэвтрүүлж, дотоод аудит, хяналт шалгалтын ажил, үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, ажлын гүйцэтгэл, шат дамжлагыг хялбарчлах, системээс мэдээлэл авах, систем ашиглаж аудит, хяналтын ажлыг гүйцэтгэж хэвших	бүртгэл, хяналт, цахим хэлбэрт шилжсэн байх.		2023-2025
	2.4.Дотоод аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн системд эрсдэлийн бүртгэл, үнэлгээг хийх.	2.4.1.Эрсдэлийн удирдлагын бүртгэл, хяналтыг системийг ашиглаж эхлэх	Эрсдэлийн бүртгэл, хяналт цахим хэлбэрт шилжсэн байх	СХДАА	2023-2025
Зорилт 3. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх.	3.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын эрсдэлийг үнэлэх.	3.1.1.Т Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын эрсдэлийг үнэлгээг хийхэд нэгдсэн удирдлагаар хангах.	ТЭЗ нар эрсдэлийн үнэлгээ хийж хэвшсэн байх.	СХДАА	2023-2025
	3.2.Эрсдэлийн удирдлагын сургалт зохион байгуулах.	3.2.1.Бүх шатны байгууллагуудад эрсдэлийн удирдлагын сургалт зохион байгуулах.	Тогтмол сургалт зохион байгуулдаг болох.	СХДАА	2023-2025
Зорилт 4. Улсын салбарын дотоод аудитын тасралтгүй сургалтын хөтөлбөр, журмын төсөл боловсруулах	4.1.Улсын салбарын дотоод аудитор бэлтгэх нэгдсэн сургалтын хөтөлбөр боловсруулах, холбогдох журмыг боловсруулахад санал хүргүүлэх	4.1.1.Мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөр, журмын төсөл боловсруулах явцад санал хүргүүлэх.	Сургалтын хөтөлбөр, журмын төсөл боловсруулхад санал хүргүүлсэн байна.	СХДАА	2023-2025